

ЦАХИМ ШУУДАНД

БАРУУН БҮСИЙН СУМДЫН ЗДТГ-ЫН ДАРГА НАРЫН “ЦЭРГИЙН БЭЛТГЭЛ” СУРГАЛТ БОЛЛОО



Баруун бүсийн аймгуудын сумдын ЗДТГ-ын дарга нартай “Цэргийн бэлтгэл” сургалтыг 2022 оны 9 дүгээр сарын 12-14-ний хооронд Ховд аймагт зохион байгуулав.

Сургалтын хүрээнд орон нутагтаа батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний

үйл ажиллагааг сурталчлах ажлыг иргэд, залуучуудад хүртээмжтэй, үр бүтээлтэй зохион байгуулж ажилласан зарим сумдын ЗДТГ-ын дарга нарыг салбарын болон бусад шагналаар шагналаа.

Тухайлбал, Алтай сумын ЗДТГ-ын

дарга Н.Батбаярыг Батлан хамгаалах яамны Жуух бичиг, Баян-Уул сумын ЗДТГ-ын дарга Ч.Болдбаярыг “Эх орны төлөө-III” хүндэт тэмдэг, Бигэр, Жаргалан, Шарга сумын ЗДТГ-ын дарга нарыг Ховд аймгийн 90 жилийн ойн медалиар тус тус шагнажээ.

НОМЫН АЧ ТУСЫГ СУРТАЛЧЛАХ ӨДӨРЛӨГ БОЛЛОО



ЦЭРГИЙН ГАВЬЯНЫ ОДОНТ ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 110 ДУГААР АНГИ

Орхон аймгийн Говил багийн “Эгшиглэн” соёлын төвийн хамт олон “Номын баяр”-ын өдөрт зориулан тус ангийн бие бүрэлдэхүүнд нүүдлийн номын сангаар үйлчлэн номын ач тусын талаар хэлэлцүүлэг өрнүүллээ.

Арга хэмжээний хүрээнд танин мэдэхүйн “АХА” асуулт хариултын тэмцээнийг явуулж, эрүүл амьдралын хэв маягийг сурталчлах, хэвшүүлэх үүднээс зумба дасгал хийв.

АХМАД Т.МӨНХ-ЭРДЭНЭ